

**“ХОТ ОРЧМЫН БЭЛЧЭЭРИЙН ТӨСӨЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл	
1	Төслийн нэр		Хот орчмын бэлчээрийн төсөл	
2	Санхүүжүүлэгч байгууллага		Мянганы Сорилтын Сан	
4	Төсөл хэрэгжүүлж буй хугацаа		2008 оны 9 сар-2013 оны 09 сар	
5	Төслийн зорилго		Хот орчмын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг (сүүний гарцыг) дээшлүүлэн малчдын орлогыг нэмэгдүүлэх.	
6	Төслийн зорилтууд		<p>1. УБ, Дархан, Хархорин, Чойбалсан хот орчмын 465 орчим бэлчээрийн нэгж талбайг малчдын бүлэгт гэрээгээр ашиглуулах системийг нэвтрүүлж, газрын эрхээр баталгаажуулан бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад чиглэнэ.</p> <p>2. Малчид болон орон нутгийн мэргэжилтнүүдийн эрчимжсэн болон хагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэх чадавхийг дээшлүүлэх.</p>	
7	Төслийн хамрах хүрээ болон үр шим хүртэгсэд		УБ, Дархан, Эрдэнэт, Хархорин, Чойбалсан хот орчмын Булган, Төв, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Өвөрхангай, Архангай, Дорнод аймгийн нийт 57 сум(дүүрэгт төсөл хэрэгжих бөгөөд 465 малчдын бүлэг/1600 орчим малчин өрхийн 5000 орчим малчид) түрээслэхэд тохиромжтой 640000 орчим га бэлчээрийг урт хугацаатай гэрээгээр ашиглан, эрчимжсэн болон хагас эрчимжсэн саалийн аж ахуй эрхэлнэ.	
8	Зардал	Төсөв/нийт шаардагдах зардал/	11,8 сая ам.доллар	
		Гүйцэтгэл (тухайн жилд)	658,2 мян.ам доллар	
		Үүнд:	Зардлын нэр	Үнийн дүн /мян.ам.доллар/
			<p>1. цалин 35,1</p> <p>2. тээврийн зардал 11,0</p> <p>3. гадаад, дотоодын томилолт 36,3</p> <p>4. богино хугацаат зөвлөхийн зардал 21,4</p> <p>5. холбооны зардал 4,3</p> <p>6. бичиг хэрэг, тавилга эд хогшлын зардал 18,0</p> <p>7. хууль эрхзүйн хороонд дэмжлэг үзүүлэх тендерт/МБМН/ 27,0</p> <p>8. бэлчээрийн газрын зураглал хийх, мэдээлэл цуглуулах тендерт 350,9</p> <p>9. бэлчээр түрээслэх, МБүлгийг сонгох ажлын тендерт/БСТөв/ 154,2</p> <p align="center">НИЙТ</p>	658,2

	Санхүүгийн талаар:	Тайлангаас харахад: МССангаас дараахь ажлуудыг тендер зарлаж, худалдан авалтын гэрээ байгуулж санхүүжилтыг олгодог. Үүнд: Хууль эрх зүйн хороонд дэмжлэг үзүүлэх ажлын тендерт МБМН шалгарч-21000 ам.доллар, бэлчээрийн зураглал хийх, мэдээлэл цуглуулах ажлын тендерт БСТөв шалгарч-350,9 мян.ам.доллар буюу нийт зардлын 53,3%, бэлчээр түрээслэх, МБүлэг сонгох явцыг дэмжих тендерт БСТөв шалгарч-154,2 мян.ам.доллар буюу нийт зардлын 23,4%-ийг тус тус эзэлж байна.
9	Төслийн хэрэгжилт	2009 оны хэрэгжилт- 75%
	<p>Түрээслэхэд тохиромжтой 465 орчим бэлчээрийн газрыг тодорхойлох хүрээнд:</p> <p>Ерөнхий дүн: 73%</p>	<p><u>Хууль эрх зүйн орчинг сайжруулах:</u> Хууль эрх зүйн хороонд дэмжлэг үзүүлэх тендерт Монголын Бэлчээрийн Менежментийн Нийгэмлэг шалгарч, гэрээ байгуулж ажилласан. Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Бэлчээрийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хороо ХХААХҮЯ-ны ХАА-н эдэлбэр газрын хэлтэстэй хамтран “ХАА-н эдэлбэр газрын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” хэлэлцүүлгийг төрийн болон ТББ, төсөл, хөтөлбөрүүд, хандивлагчдын дунд зохион байгуулжээ.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-20%</p> <p><u>Бэлчээрийн зураг үйлдэх, байгаль орчны үнэлгээ хийх:</u> УБ, Дархан, Эрдэнэт хот орчимд гэрээгээр ашиглуулахад тохиромжтой 325 бэлчээрийг сонгох болон тухайн газарт амьдарч буй малчдад зориулсан сургалт сурталчилгааны аян зохион байгуулах, Малчдын бүлэг шалгаруулах ажлын гүйцэтгэгчээр Бодлого судлалын төв шалгарч, дээрх хот орчимд саалийн аж ахуй эрхлэхэд тохиромжтой газрыг сонгох, малчдад төсөлд хамрагдахад нь туслах ажлыг хийсэн байна. GIS мэдээллийн баазын тайлан, дижитал газрын зургийг 2009 оны 9 сард хүлээлгэн өгсөн. Байгаль орчны үнэлгээний ажил хийгдэж эхэлсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-70%</p> <p><u>Малчдын бүлэг(фермер) шалгаруулах шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах:</u> Шалгуур үзүүлэлтийн загварыг төслийн суурь судалгаанд тулгуурлан хийсэн бөгөөд дараахь байгууллагуудын саналыг авч тусгасан. Үүнд: Орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүд (680 хүн), ХХААХҮЯ, Нийслэлийн ХХААГ, Улсын мал эмнэлэг, үржлийн газар, Эрх зүйн санал боловсруулах хороо, БСТөв, МААЭҮХ, ММССангийн оролцогчдын хорооны гишүүд, ММССангийн хуульчид, МСК.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-100%</p> <p>Сум, дүүрэгт Малчдын бүлэг(фермер) сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах: Нийт 57 сум, дүүрэгт “Ажлын хэсэг” байгуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-100%</p>

		<p>Малчдын бүлгийг сонгон шалгаруулах: Бэлчээр түрээслэх малчдын бүлэг сонгох явцыг дэмжих тендерт БСТ шалгарч, нийт 623ш өргөдөл хүлээн авснаас 464 бүлгийг эхний шалгаруулалтаар сонгосон. Эхний шалгаруулалтад тэнцсэн бүлгийн Бизнес саналыг мэргэжлийн баг үнэлж эхлээд байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт- 75%</p>
10	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>“Хот орчмын бэлчээрийн төсөл”-ийн хэрэгжүүлэх гол ажлууд нь 2010 оноос хэрэгжүүлэх юм. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> • 300 малчны бүлэгтэй хийх гэрээг 2010 онд • Худаг шинээр гаргах, уст цэгийг сэргээх • Өвөлжөө болон шаардлагатай газрыг хаших хашааны материалаар хангах • Малчдын бүлэг, орон нутгийн мэргэжилтнүүдэд зориулсан бэлчээр, МАА, бизнес, маркетинг, менежментийн сургалтын тендер худалдан авалтын шатанд явж байгаа. <p>ММССангийн “Хот орчмын бэлчээрийн төсөл”-ийн өргөтгөл буюу мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор нэмж 5 сая орчим америк долларын санхүүжилтыг 2009 оны 9 дүгээр сард МСК-ийн Удирдах зөвлөл баталсан нь тус төслийн эрчимтэй үйл ажиллагааг харуулж байна. Тус өргөтгөл нь Өвөрхангай, Архангай, Дорнод аймгуудын нийт 165 малчдын бүлгийг хамрах бөгөөд үйл ажиллагааны бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p>Төслийн 2009 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд 75% буюу “Шаардлага хангаж байгаа” гэсэн үнэлгээг өгч байна.</p>
11	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	Хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажиллаж байна.
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж	<ol style="list-style-type: none"> 1. Төслийн үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор хуулиудад холбогдох өөрчлөлтүүдийг оруулан батлуулах. 2. 300 малчин өрхийн сонгон шалгаруулах явцыг эрчимжүүлж, гэрээ хийх 3. Малчид болон орон нутгийн мэргэжилтнүүдийн эрчимжсэн аж ахуй эрхлэх чадавхийг сайжруулах 4. Хот суурин газрын иргэдийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг сайжруулах. 5. Төслийн баг ХХААХҮЯ-тай үйл ажиллагаагаа уялдуулж, хамтран ажиллах.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА